



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-7

1.Дэд хороодын дарга нарыг сонгох тухай	4-7
---	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
07 дугаар сарын 09-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 29 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж;
Чөлөөтэй: Б.Бейсен, С.Амарсайхан, П.Батчимэг, С.Ганбаатар,
Ж.Золжаргал, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Н.Наранбаатар, Ц.Туваан, Ж.Чинбүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: З.Мэндсайхан.

Нэг.Дэд хороодын дарга нарыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайг Агаар, орчны бохирдлын дэд хорооны даргад, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайг Хүнс, хөдөө аж ахуйн дэд хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар тус тус танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бат-Эрдэнэ: Агаар, орчны бохирдлын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	0
Бүгд:	15

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Б.Бат-Эрдэнэ: Хүнс, хөдөө аж ахуйн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхайг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ “Дэд хороодын дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бат-Эрдэнэ: “Дэд хороодын дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 16 цаг 29 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн учраас 51.7 хувьд хүрсэн учраас БОХХААБХ 2025 оны 7 сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагай, Очирбатын Амгаланбаатар, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Жигжидийн Батжаргал, Гомбын Ганбаатар, Мөнгөнцогийн Ганхүлэг, Гонгорын Дамдинням, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Сонгобайн Замира, Цагаанхүүгийн Идэрбат, Мэндбаярын Мандхай, Тогтмолын Мөнхсайхан, Салдангийн Одонтүяа, Ухнаагийн Отгонбаяр, Агваанлуvsангийн Ундраа гишүүд хуралдаанд оролцож байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Дэд хороодын дарга нарыг сонгох тухай тогтоолын төслийг хэлэлцүүлнэ.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Тогтоолын төслийг баталъя хэлэлцэх асуудлыг баталъя. Хэлэлцэх асуудлууд руу оръё.

Дэд хороодын даргыг сонгох асуудлаар Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Аюушийн Ариунзаяа гишүүнийг урьж байна аа. Микрофоныг нээж өгье.

А.Ариунзаяа: БОХХАА-н байнгын хорооны эрхлэх асуудалд Агаар орчны бохирдлын дэд хороо хамаарагдаж байна. Агаар орчны бохирдлын дэд хорооны даргад Наранцэцэгийн Алтаншагайг дэвшүүлж байна аа.

Наранцэцэгийн Алтаншагай 1984 онд төрсөн, Архангай аймагт төрсөн. Эхнэр 3 хүүхдийн хамтаар амьдардаг. 2002 онд Архангай аймгийн 3 дугаар дунд сургууль, 2017 онд Улаанбаатар Эрдэм их сургуульд Нийгмийн ажилтан мэргэжлээр, 2019 онд Удирдлагын академийг төрийн захиргааны менежментээр, 2020 онд МУИС-д Улс төр судлалын магистр мэргэжлээр төгссөн, 2008-аас 2011 онд Нийслэлийн МАН-ын хороонд улс төрийн ажилтан, 2011-ээс 2012 онд Нийслэлийн МАН-ын хорооны Зохион байгуулалтын хэлтсийн дарга, 2011-ээс 2017 онд СХД-ийн МАН-ын хорооны дэд дарга, 2017-гоос 2018 онд СХД-ийн ЗДТГ Засаг даргын орлогч, 2018-

аас 2020 онд Нийслэлийн МАН-ын хорооны дэд дарга, 2020-2024 онд СХД-ийн Засаг даргаар тус тус ажиллаж байсан туршлагатай.

Наранцэцэгийн Алтаншагай 2024 оноос Монгол УИХ-ын гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд ажлын туршлага, төрийн албанд ажилласан мэдлэг ур чадварыг харгалзан Агаар орчны бохирдлын дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна аа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Дараагийн ээлжийн дэд хороо ХХАА-н дэд хороо. ХХАА-н дэд хорооны даргад Мэндбаярын Мандхайг дэвшүүлж байна.

Мэндбаярын Мандхай нь 1981 онд Улаанбаатар хотод төрсөн. Нөхөр 3 хүүхдийн хамтаар амьдардаг. 1998 онд МУИС-ийн дэргэдэх хэл бичгээр гүнзгийрүүлсэн лицей сургуулийг төгссөн. 2002 онд Аялал жуулчлалын удирдлагын дээд сургуулийг эко аялал жуулчлалын менежментээр төгссөн. 2006-аас 2008 онд Англи улсад Хэрэглэгчийн зөвшөөрөл Комплайнс хариуцсан мэргэжилтнээр ажилласан. 2008-аас 2009 онд Ази Номхон Далайн хөрөнгө оруулалтын Партнерс компанид Маркетинг төслүүд хариуцсан менежер, 2009-өөс 2011 онд Нортонсек брокер Диллер Андеррайтерын Бизнес хөгжил хариуцсан захирлаар ажилласан. 2011-ээс 2015 онд Оюу Толгой компанид нийгмийн төслүүд хариуцсан төслийн менежер, 2015-аас 2016 онд Нүүдэлчин группийн Бизнес хөгжил хариуцсан захирал, 2016-аас 2018 онд Монголжин стратегийн зөвлөх компанид зөвлөхөөр ажилласан. 2018-аас 2021 онд Сүү компанийн ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилласан. 2021-ээс 2023 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр Бизнес ба Хүний эрх төслийн үндэсний зөвлөхөөр ажилласан. 2023-аас 2024 онд Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны ЕНБД-аар ажилласан туршлагатай байна.

2024 оноос Монгол УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Мэндбаярын Мандхайн ажлын туршлага, мэдлэг ур чадварыг харгалзан УИХ-ын ХХАА-н дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна аа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Б.Бат-Эрдэнэ: Аюушийн Ариунзаяа гишүүнд баярлалаа.

Нэг горимын санал байна. Чуулган дээр цахим санал хураалт болон техникийн гацалтууд үүссэн.

Өнөөдөр үдээс өмнөх БОХХАА-н байнгын хороо болон Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хорооны үеэр техникийн саатлууд бас гарсан. Ийм учраас санал хураалтыг гараар явуулах ийм горимын саналтай байна аа.

Горимын саналыг дэмжиж өгөхийг Байнгын хорооны гишүүдээсээ хүсэж. За баярлалаа.

Байнгын хорооны гишүүдийн саналаар 15-аас 15 гишүүний саналаар гараар тоолохоор боллоо. Баярлалаа.

Агаар орчны бохирдлын дэд хорооны даргад УИХ-ын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайг, ХХАА-н дэд хорооны даргад Мэндбаярын Мандухай нарыг нэр дэвшүүлсэн байна.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д дэд хорооны даргыг дэд хорооны гишүүдийн дотроос нэр дэвшүүлж Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар сонгоно гэж заасан.

Үүний дагуу дэд хороодоос дэд хороодод орсон УИХ-ын гишүүдээс бол саналыг авсан.

Дэд хороодын даргад нэр дэвшигчдээс асуулт, саналтай гишүүд байна уу? Асуулт болон үг нэг дор. Асуулт санал үг хэлэх хүн байхгүй байна. Тасаллаа.

Ийм учраас санал хураалтдаа бүгдээрээ орёё.

УИХ-ын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайг Агаар орчны бохирдлын дэд хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг горимын саналын дагуу гараар явуулъя.

15-аас 15 хүний санал буюу 100 хувийн саналаар дэмжлээ.

УИХ-ын гишүүн Мэндбаярын Мандхай ХХАА-н дэд хороон даргаар сонгохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг горимын саналын дагуу гараар явуулъя. Гар тооллогоор явуулъя.

15-аас 15 хүний саналаар дэмжигдлээ.

Та бүхэндээ Байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол УИХ-ын байнгын хорооны тогтоол

2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр. Улаанбаатар хот.

“Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Монгол УИХ-ын тухай хуулийн 27 дугаар зүйл., Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг Санал хураалтын дүнг үндэслэн БОХХАА-н Байнгын хорооноос тогтоох нь:

1. Агаар орчны бохирдлын дэд хорооны даргаар УИХ-ын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайг, ХХАА-н дэд хорооны даргаар УИХ-ын гишүүн Мэндбаярын Мандхай нарыг сонгасугай.

БОХХАА-н байнгын хор хорооны хуралдаан даргалагч Б.Батэрдэнэ гэсэн тогтоолын төслийг та бүхэндээ танилцуулж байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой санал асуулт байна уу? Байхгүй байна.

Тогтоолын төслийг баталъя.

Горимын саналын дагуу гараар санал хураалтыг явуулъя.

15-аас 15 гишүүн санал өгсөн учраас тогтоолын төслийг баталъя аа.

Дэд хорооны даргаар сонгогдсон Алтаншагай, Мандхай гишүүддээ баяр хүргэж ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе өө.

БОХХАА-н байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан учраас хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа.

16.37 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА